



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**“Архангайд үйлдвэрлэв” ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан**

Аудитын код: АРА-2025/001/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.open.audit.mn</p> <p>Архангай аймаг 2025 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerquibaatar@audit.gov.mn Аудитор А.Пүрэвцэцэг Утас: 99746363 Цахим хаяг: Purevtsetsega@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ	1
1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
3.1 Албан шаардлага	8
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	10

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025. 03. 15 № 146-
танай _____-ны № _____-т

“АРХАНГАЙД ҮЙЛДВЭРЛЭВ”
ОНӨААТҮГ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Г.АЛДАРТБААТАР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Архангайд үйлдвэрлэв” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

- Тайлант онд 3,765.2 мянган төгрөгийн худалдан авалтын гүйлгээ цахим баримтгүй
- 2024 онд 66,086.4 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Эдгээр зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалт, аймгийн ИТХ-ын 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 43 дугаар тогтоолоор баталсан “Архангайд үйлдвэрлэв” ОНӨААТҮГ-ын дүрмийн 5.7.5-д “Үйлдвэрийн газрын төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулж биелэлтийг хангуулах үүрэгтэй” гэсэн заалтыг тус тус зөрчсөн, санхүүгийн

тайлагналын иж бүрэн байх, эрх ба үүрэг, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитын гол асуудал

“Архангайд үйлдвэрлэв” ОНӨААТҮГ-ын 2024 оны Бизнес төлөвлөгөөг боловсруулан аймгийн Засаг даргаар 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдөр орлогыг 251,662.0 мянган төгрөг, нийт зардлыг 250,090.4 мянган төгрөг, 1,571.5 мянган төгрөгийн ашигтай ажиллахаар батлуулсан боловч гүйцэтгэлээр 6,883.6 мянган төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлж, зардлыг 60,774.5 мянган төгрөг буюу 24.3 хувиар хэтрүүлэн зарцуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			/төгрөгөөр/	
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>43,626,893.76</u>	<u>29,759,637.21</u>	
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	<u>35,124,640.76</u>	<u>19,831,525.53</u>	
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	35,124,640.76	19,831,525.53	
3121	Төгрөг	35,124,640.76	19,831,525.53	
31213	Арилжааны банк дахь харилцах	35,124,640.76	19,831,525.53	
33	АВЛАГА	<u>5,085,253.00</u>	<u>5,091,111.68</u>	
33401	Дансны авлага /ТӨҮГ/	3,940,758.00	3,859,998.00	
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	1,144,495.00	1,231,113.68	
35	БАРАА МАТЕРИАЛ	<u>3,417,000.00</u>	<u>4,837,000.00</u>	
35300	Бэлэн бүтээгдэхүүн	2,737,000.00	3,757,000.00	
354	Хангамжийн материал	<u>680,000.00</u>	<u>1,080,000.00</u>	
35420	Аж ахуйн материал	680,000.00	1,080,000.00	
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,782,228,501.52</u>	<u>2,724,594,817.96</u>	
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	<u>2,782,228,501.52</u>	<u>2,724,594,817.96</u>	
392	Биет хөрөнгө	<u>2,770,278,501.52</u>	<u>2,712,644,817.96</u>	
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,899,489,084.00	2,899,489,084.00	
39202	Хуримтлагдсан элэгдэл	(191,328,669.04)	(239,653,487.11)	
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	6,218,900.00	6,838,800.00	
39206	Хуримтлагдсан элэгдэл	(3,489,475.00)	(4,671,867.50)	
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,862,100.00	14,862,100.00	
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,946,089.99)	(7,236,409.99)	
39214	Бусад үндсэн хөрөнгө	71,490,530.00	72,010,530.00	
39215	Хуримтлагдсан элэгдэл	(21,017,878.44)	(28,993,931.44)	
393	Биет бус хөрөнгө	<u>11,950,000.00</u>	<u>11,950,000.00</u>	
39301	Програм хангамж	12,854,000.00	12,854,000.00	
39302	Хуримтлагдсан элэгдэл	(904,000.00)	(904,000.00)	
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,825,855,395.28</u>	<u>2,754,354,455.17</u>	
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>34,596,141.90</u>	<u>29,917,734.67</u>	
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	34,596,141.90	29,917,734.67	
413	Өглөг	5,434,271.90	854,954.67	
4136	Бусад өглөг	5,434,271.90	854,954.43	
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	5,434,271.67	854,954.20	
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	0.23	0.23	
414	Урьдчилж орсон орлого	29,161,870.00	29,062,780.00	
41440	Бусад урьдчилж орсон орлого	29,161,870.00	29,062,780.00	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,790,523,188.69</u>	<u>2,724,436,720.50</u>	
51	Засгийн газрын хувь оролцоо	2,790,523,188.69	2,724,436,720.50	
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,154,084,200.00	3,154,084,200.00	

“Архангайд үйлдвэрлэв” ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

51101	Өмч: - төрийн	3,154,084,200.00	3,154,084,200.00
512	Хуримтлагдсан үр дүн	(363,561,011.31)	(429,647,479.50)
51210	Өмнөх үеийн үр дүн	(363,561,011.31)	(363,561,011.31)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(66,086,468.19)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,825,119,330.59</u>	<u>2,754,354,455.17</u>

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлтийн нэр	Өмнөх үеийн дүн	Тайлант хугацаа
1. Борлуулалтын орлого(Цэвэр орлого)	<u>218,449,300.91</u>	<u>244,778,470.87</u>
2.Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		
3. Нийт ашиг (алдагдал)	<u>218,449,300.91</u>	<u>207,775,109.59</u>
10. Ерөнхий ба удирдлагын зардал	285,000,935.05	310,501,239.06
12. Бусад зардал	169,300.00	363,700.00
13.ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		
18. Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	<u>(66,720,934.14)</u>	<u>(66,086,468.19)</u>
19. Орлогын татварын зардал		
20. Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		
24. Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	<u>(66,720,934.14)</u>	<u>(66,086,468.19)</u>

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Нийт дүн
1	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,154,084,200.00	(297,483,114.85)	2,856,601,085.15
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	643,037.68	643,037.68
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,154,084,200.00	(296,840,077.17)	2,857,244,122.83
7	Тайлант үеийн үр дүн	00.00	(66,720,934.14)	(66,720,934.14)
8	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,154,084,200.00	(363,561,011.31)	2,790,523,188.69
9	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,154,084,200.00	(430,281,945.45)	
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	0.00
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,154,084,200.00	(363,561,011.31)	2,790,523,188.69
16	Тайлант үеийн үр дүн	00.00	(66,086,468.19)	(66,086,468.19)
17	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,154,084,200.00	(429,647,479.50)	2,724,436,720.50

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлтийн нэр	Өмнөх үеийн дүн	Тайлант хугацаа
1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	<u>237,967,266.00</u>	<u>262,849,151.91</u>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	213,255,455.00	225,972,819.91
Бусад мөнгөн орлого	24,711,811.00	36,876,332.00
1.2 Мөнгөн зарлагын дүн	<u>244,492,881.92</u>	<u>278,712,367.14</u>
Ажиллагчдад төлсөн	86,095,369.00	101,591,376.69
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	23,950,173.41	26,631,743.01
Бараа материал худалдан авахад төлсөн	22,220,959.00	20,893,430.00
Ашиглалтын зардал төлсөн	65,076,043.25	73,279,505.6
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		
Татварын байгууллагад төлсөн	33,121,886.26	40,920,258.65
Бусад мөнгөн зарлага	14,028,451.00	15,396,053.19
1.3 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	<u>(6,525,615.92)</u>	<u>(15,863,215.23)</u>
2. Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ		
2.1 Мөнгөн орлогын дүн	3,321,000.00	1,710,000.00
2.2 Мөнгөн зарлагын дүн	8,518,000.00	1,139,900.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	8,518,000.00	1,139,900.00
2.3 Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	<u>(5,197,000.00)</u>	<u>570,100.00</u>
3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1 Мөнгөн орлогын дүн		
3.2 Мөнгөн зарлагын дүн		
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.3 Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(11,722,615.92)	(15,293,115.23)
Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	<u>46,847,256.68</u>	<u>35,124,640.76</u>
Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<u>35,124,640.76</u>	<u>19,831,525.53</u>

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

ДД	Зардлын зүйл анги	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Цалин	121,050,000.00	121,364,797.00	314,797.00	0.26
2	НДШ	14,347,008.00	14,026,578.01	(320,429.99)	(2.23)
3	Бичиг хэрэг	1,753,200.00	863,200.00	(890,000.00)	(50.76)
4	Тээвэр шатахуун	-	88,000.00	88,000.00	100.00
5	Гэрэл цахилгаан	50,926,380.00	57,736,383.00	6,810,003.00	13.37
6	Түлш халаалт	10,650,000.00	10,650,000.00	-	-
7	Цэвэр бохир ус	9,131,520.00	10,797,123.79	1,665,603.79	18.24
8	Хангамж бараа материалын зардал	12,199,600.00	20,893,430.00	8,693,830.00	71.26
9	Бусад зардал	11,985,850.00	23,720,168.54	11,734,318.54	97.90
10	Үндсэн хөрөнгө олж эзэмших	650,000.00	1,139,900.00	489,900.00	75.37
11	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	17,396,940.00	17,432,786.80	35,846.80	0.21
11	Зардлын нийт дүн	250,090,498.00	278,712,367.14	28,621,869.14	11.44

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 904.0 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залруулсан. Залруулсан алдаа:

Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 904.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг холбогдох байгууллагын шийдвэргүй данснаас хассан зөрчлийг залруулав.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, 14.4.2, 15.1,15.2 дахь заалтууд, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдлийн хангахгүй байна.

Залруулагдаагүй 5,614.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд алдаа зөрчлийг таслан зогсоох 6 албан шаардлага хүргүүллээ.

Аудитаар залруулагдаагүй материаллаг 6 зөрчилтэй асуудал нь 5,614.1 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 1,761.6 мянган төгрөгөөс их байгаа тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

3.1.1 Тайлант онд цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй 3,765.2 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн “5.1.4-т “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, “, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т “Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

3.1.2 Тайлант онд 11 албан хаагчдын цалинг 913.9 мянган төгрөгийг зөрүүтэй тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т “Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална” 4.1.3-т “үр ашигтай байх”, 4.1.6-д “Сахилга баттай байх”, 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

3.1.3 Тайлант онд 244,710.2 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэн 310,958.3 мянган төгрөгийн зардал гаргаж 66,248.0 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах”, аймгийн ИТХ-ын 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 43 дугаар тогтоолоор баталсан “Архангайд үйлдвэрлэв” ОНӨААТҮГ-ын дүрмийн 5.7.5-д “Үйлдвэрийн газрын төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулж биелэлтийг хангуулах үүрэгтэй” гэсэн заалттай нийцэхгүй байна.

“Архангайд үйлдвэрлэв” ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Шийдвэрлэсэн нь: Бизнес төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх талаар тодорхой арга хэмжээг авч ажиллах албан шаардлага хүргүүлээ.

3.1.4 Тайлант онд 251,662.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 250,090.4 мянган төгрөгийн зардал гаргаж, 1,571.5 мянган төгрөгийн ашигтай ажиллагааг аймгийн засаг даргаар төлөвлөгөөг батлуулсан боловч бизнес төлөвлөгөөнд төлөвлөснөөс 6,883.5 мянган төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлж, 60,774.5 мянган төгрөгийг хэтрүүлэн зарцуулж, 66,086.4 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Энэ нь аймгийн Засаг дарга “Архангайд үйлдвэрлэв” ОНӨААТҮГ-ын даргатай 2024 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний 3.2.16-д “Энэхүү гэрээний хавсралт болох байгууллагын 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээг үр дүнгийн үзүүлэлт, шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшинд хүргэж бүрэн хэрэгжүүлж ажиллах” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: “Архангайд үйлдвэрлэв” ОНӨААТҮГ-ын ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, хамтран ажиллах гэрээний үүргийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг авч ажиллах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлээ .

3.1.5 Түрээслэгчидтэй тухай бүр тооцоо нийлж барагдуулах арга хэмжээ аваагүйгээс 934.9 мянган төгрөгийг зөрүү үүссэнийг нягтлан бодох бүртгэл, тайланд тусгахгүй орхигдуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана" , Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь ” Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах....” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс											
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Түрээс, гэрлийн мөнгийг зөрүүтэй тооцож нэхэмжилсэн	1	934.9			1	934.9								
Цалинг зөрүүтэй тооцсон	1	913.9			1	913.9								
Анхан шатны баримтын бүрдэл дутуу	1	3765.2			1	3765.2								
Бизнес төлөвлөгөө, гэрээний хэрэгжилтийг хангаагүй алдагдалтай ажилласан	2				2									
Дүн	5	5,614.1			5	5,614.1								

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан	1	0.0			1					0.0
Дүн	1	0.0			1					0.0